

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар									
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			14	
Уулзалтын №		82							
Огноо		2019 оны 11 сарын 29			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			13	
ХУРЛЫН ДАРГА									
Нэр/ Байгууллага		Овог	Бямбасүрэн			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			ТИЙМ
		Нэр	Мягмар			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)			3.40
		Байгууллага	МҮЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга			Хурал зохион байгуулагдсан газар	ЭМЯ-ны хурлын танхим А		
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Тохирох нүдийг бөглөнө үү)		Дарга			x	Уулзалтын төрөл (Тохирох нүдийг бөглөнө үү)		Ээлжит	x
		Дэд дарга						Ээлжит бус	
		Гишүүн						Хорооны уулзалт	
		Гишүүнийг орлогч				Бусад байгууллагын оролцоо (Тохирох нүдийг бөглөнө үү)		СОНА	x
Салбар * (Тохирох нүдийг бөглөнө үү)				FRM / PO					
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эрсдэлт бүлгийн хүн ам	Шашны Байгууллага	Хувийн Хэвшил	бусад	x
							x	оролцоогүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүдийг бөглөнө үү)													
ҮЗЗ-ИЙН ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД													
Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хянах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тэгш байдал	Төсөл боловруулах	УХА, СХА	Тэтгэлэг	Хяналт (удирдлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн Пүе/, хаалт	Техникийн туслалцаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр #1		Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах.											
x													
Хөтөлбөр #2		ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн үйл ажиллагааны биелэлтийг танилцуулах (Хяналтын хорооноос гарсан шийдвэрийн дагуу) <ul style="list-style-type: none"> Төслийн шугамаар бэлтгэгдсэн эмч нарын мэдээлэл; 											
x													

Хөтөлбөр	
№.	Хөтөлбөрийг дурдана уу
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах.
Хөтөлбөр #2	ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн үйл ажиллагааны биелэлтийг танилцуулах (Хяналтын хорооноос гарсан шийдвэрийн дагуу) <ul style="list-style-type: none"> Төслийн шугамаар бэлтгэгдсэн эмч нарын мэдээлэл;

	<ul style="list-style-type: none"> Жене-экспертийн ашиглалтын байдал; Эмчилгээ алдагдалт, лабораторийн чанар <p><i>Асуулт хариулт</i></p>														
Хөтөлбөр #3	Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай тайланг танилцуулах. <i>Асуулт хариулт</i>	x										x			
Хөтөлбөр #4	Глобаль сангийн үйл ажиллагатай холбоотой Эрүүл мэндийн сайдын А/460, А/511 тоот тушаалуудын хэрэгжилтийг танилцуулах; 2021-2023 онуудад хэрэгжүүлэх Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах <i>Асуулт хариулт</i>	x					x		x						
Хөтөлбөр #5	Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын талаар ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулан, санал авах.	x										x			
Хөтөлбөр #6	Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжийг танилцуулж батлах <i>Асуулт хариулт</i>	x											x		
Хөтөлбөр #7	Зохион байгуулалтын асуудал: <ul style="list-style-type: none"> ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох 				x	x									
Хөтөлбөр #8	Оройн зоог-Блюе Скай зочид буудлын Топаз Хурлын танхимд														

Хөтөлбөр тус бүрээр хийсэн тэмдэглэл	
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцүүлэх асуудлууд, өмнөх хурлын шийдвэрийн биелэлтийг танилцуулах.
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.	
Байхгүй.	
Ямар нэгэн маргаан гарсан эсэх(тийм эсвэл үгүй)>	үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй	

Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар хурлыг даргалан хурлын хөтөлбөрийг гишүүдэд танилцуулж, гишүүдийн саналаар Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжийг танилцуулж батлах болон ҮЗЗ-ийн зохион байгуулалтын асуудлыг хамгийн сүүлд хэлэлцэхээр хөтөлбөрийг батлав.

Өмнөх 81 дэх хурлын шийдвэрийн үйл явцын талаар **ҮЗЗ-ийн зохицуулагч Б.Оюундарь** гишүүдэд танилцуулав.

ХУРАЛ 2019 ОНЫ 06 САРЫН 21-НД БОЛСОН

ХӨТӨЛБӨР	ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ГҮЙЦЭТГЭЛ
хөтөлбөр#3	<p>1. Танилцах айчлалын хүрээнд зөвлөмж гаргахдаа ЭМЯ-нд өөрсдийнх нь асуудалтай холбоотой бодлогын шинжтэй асуудлуудаар, тухайн орон нутгийн ЗДТГ, шаардлагатай тохиолдолд Иргэдийн хуралд болон тухайн очсон СХА буюу очсон байгууллагатай холбоотой 3 чиглэлээр зөвлөмж боловсруулан хүргүүлье.</p> <p>2. Тайлангуудын загвар өөр байгаа тул ҮЗЗ-ийн Ажлын албанаас ҮЗЗ-ийн хурал дээр илтгэл тавихаас өмнө илтгэл тавих хүмүүсийн саналыг тусган зөвлөмжийн нэгдсэн загварт оруулан ҮЗЗ-ийн гишүүд шууд зөвлөмжөө хэлэлцдэг байдалруу дараагийн хурлаас эхлэн шилжих.</p> <p><i>Дээрх шийдвэрүүдийг гишүүд санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа.</i></p>	<p>ҮЗЗ-ийн Ажлын Алба</p> <p>90%</p>
хөтөлбөр#4	<p>ҮЗЗ-ийн Ажлын Албанаас хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг 2019-2020 оны ҮЗЗ-ийн хяналтын төлөвлөгөөнд тусган ҮЗЗ-ийн нийт гишүүдэд хүргэж саналыг авах хэрэгтэй гэсэн саналыг нийт гишүүд санал нэгтгэйгээр баталлаа.</p>	<p>ҮЗЗ-ийн Ажлын Алба</p> <p>100%</p>
хөтөлбөр#5	<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн дараагийн буюу 82 дахь удаагийн хурлаар ҮЗЗ-ийн даргыг сонгох асуудлыг хэлэлцэх асуудалд оруулан хэлэлцэхээр нийт гишүүдийн 10 нь гар өргөн баталлаа. Ингэхдээ дүрмийн хэрэгжилтийг хангахын тулд олонхийн буюу нийт гишүүдийн 2/3-ын ирцийг бүрдүүлэн ажиллах тал дээр Ажлын алба онцгой анхааран ажиллахыг үүрэг болгов. • ҮЗЗ-ийн гишүүд ҮЗЗ-ийн Хяналтын хорооны даргаар ТБ-ыг төлөөлж буй гишүүн Ж.Мөнхжаргалыг санал нэгтгэйгээр гар өргөн баталлаа. 	<p>ҮЗЗ-ийн гишүүд</p> <p>100%</p>
Хөтөлбөр #2	<p>ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн үйл ажиллагааны биелэлтийг танилцуулах (Хяналтын хорооноос гарсан шийдвэрийн дагуу)</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн шугамаар бэлтгэгдсэн эмч нарын мэдээлэл; • Жене-экспертийн ашиглалтын байдал; • Эмчилгээ алдагдалт, лабораторийн чанар <p><i>Асуулт хариулт</i></p>	
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.		
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (гийм эсвэл үгүй)>		Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй		
<p>Төслийн шугамаар бэлтгэгдсэн БЗДХ-ын эмч нарын мэдээлэл /Хавсралт №2/ О.Энхжаргал, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын эмч: “Глобал сангийн дэмжлэгтэй ХДХВ, ДОХ-ын төслийн</p>		

хүрээнд орон нутгийн эмч нарыг”БЗДХ, ХДХВ, ДОХ судлал” төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх сургалт” танилцуулгыг танилцууллаа.

Аймагт БЗДХ-ын тусламж үйлчилгээ үзүүлж буй эмчийн тоо 53 байхаас 24 эмч буй 43% нь ажиллаж байна. Дээрх ажиллаж буй эмч нараас 7 аймгийн эмч нар тэтгэвэрээ тогтоолгосон боловч ажиллах эмчгүй тул түр гэрээ байгуулан ажиллаж байгаа бол 5 аймгийн их эмч 50-аас дээш насныхан байна.Төв, Дорнод аймгийн 2 эмч нярайн тэтгэмжит чөлөөтэй байна.

2018 оны 05 сарын 15-ны өдрийн ЭМС-ын А/186 тоот тушаалаар:

- Сүрьеэ, БЗДХ, ХДХВ, ДОХ судлалын сургалтын хөтөлбөр боловсруулах
- Сүрьеэ, БЗДХ, ХДХВ, ДОХ судлалын төрөлжсөн мэргэшлийн эмч бэлтгэхэд шаардлагатай сургалтын зардлыг Глобал сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх

Сургалтын хугацаа:

2018 оны 10 сараас-2019 оны 4 сар

- Онол-лекц-10 сэдвээр/ХӨСҮТ, ЭМШҮИС/
- Семинар- 52 сэдвээр/ДОХ/БЗДХ/ТСА /
- Бие даалт- 4 сэдвээр/ДОХ/БЗДХ/ТСА /
- Дадлага- /ДОХ/БЗДХ/ТСА, Дүүрэг, ТББ/
- Гардан үйлдэл-32 сэдвээр /ДОХ/БЗДХ/ТСА /
- Лабораторийн дадлага /ДОХ/БЗДХ-ын лаборатори/

Глобал Сангийн дэмжлэгээр хөдөө орон нутагаас нийт 13 эмч нар 29 орчим сая төгрөгөөр сургагдсан Эдгээрээс 8 нь яг энэхүү суралцаж төгссөн мэргэжлийнхээ дагуу ажиллаж байна. 2 эмч халдвартын чиглэлээр ажиллаж байгаа бол 3 нь жирэмсний амралттай байна.

Түүнчлэн Өмнөговь аймгаас сургагдсан эмчийн хүлээн авсан хоосон өрөөний тохижилтыг гадна дотны байгууллагуудын дэмжлэгтэйгээр бүрдүүлсэн жишээг харууллаа.

Төслийн шугамаар бэлтгэгдсэн сүрьеэгийн эмч нарын мэдээлэл, Жене-экспертийн ашиглалтын байдал /Хавсралт №3/

П.Насанжаргал, ХӨСҮТ-ийн СТА-ны эмч: Глобал сангийн төслөөр сүрьеэ судлалын сургалтанд хамрагдсан эмч нарын мэдээлэл, Жене-экспертийн ашиглалтын байдал, лабораторийн чанар зэргийн талаар танилцууллаа.

- Глобал сан-15, Байгууллага-2, Төрийн сан-1 нийт 18 эмчийг сургасан байна.

Урьдчилсан байдлаар эдгээр төгсөгчдөөс хүний нөөцийн хувьд дутагдалтай байгаа нэгжүүдэд 10 эмч ажиллаж эхлэхэд:

- 2017 онд 83 эмч ажиллаж байсан – 41% дутагдалтай
- 2019 онд 100 эмч ажиллаж байгаа нь – 30 % дутагдалтай
- 2020 онд 118 эмч ажиллах нь - 17 % дутагдалтай

2019-2020 оны сургалтаар 13%-ийн хүний нөөцийн хангалт хийгдэх боломжтой юм.

Сүрьеэгийн лаборатори

Түрхцийн лабораториудад гадаад чанарын үнэлгээг давтан шалгах аргаар улирал тутам, ур чавдарын сорилоор жилд 1 удаа үнэлдэг бөгөөд үүгээр лабораториудын 95 гаруй хувь нь хангалттай гүйцэтгэлтэй байна.

Анх манай улсад 2013 оноос СҮЛЛ-т жене эксперт шинжилгээг ашиглаж эхэлснээс хойш жил тутам өргөжсөөр одоогийн байдлаар 14 аймаг, 3 дүүрэг, хорих, ХӨСҮТ, нийт 19 нэгжид жене эксперт аппаратыг суурилуулан ажиллаж байна.

Жене эксперт шинжилгээг уушгины болон уушгины бус сүрьеэ, хүүхдийн сүрьеэ, ЭТС-ийн оношилгоо болон эрсдэлтэй бүлгийн хүн амын дундах идэвхитэй илрүүлэлт энд ашиглаж байна. Жилээс жилд шинжилгээний тоо нэмэгдэж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 10656 шинжилгээг гүйцэтгэсэнээс 1921 эерэг тохиолдол, 165 рифампицинд тэсвэртэй тохиолдол илрүүлсэн байна.

Дүгнэлт

- 2018-2020 онд зохион байгуулсан сургалтаар 24%-ийн хүний нөөцийн хангалт хийгдэх боломжтой болсон ч 17%-ийн дутагдал байсаар байна. Иймд сүрьеэгийн их эмчийн тасралтгүй сургалтыг цаашид дор хаяж 2 жил үргэлжлүүлэх, дунд мэргэжилтний сургалтыг эхлүүлэх шаардлагатай байна.
- Одоогоор 13 лаборатори флюоресценц микроскоп, 14 аймаг, 3 дүүрэг GeneXpert ашиглаж байгаа ба цаашид эдгээр лабораториудын тоог нэмэгдүүлэх, идэвхитэй илрүүлэг зохион байгуулах зэргээр GeneXpert аппаратын ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Нэгж лабораториудад шинэ арга технологи нэвтрүүлж байгаатай холбоотой лабораторийн мэргэжилтнүүдэд шинэ арга технологийг эзэмшүүлэх, дадлагажуулах зорилгоор олгох болон давтан сургалтуудыг тасралтгүйгээр явуулах хэрэгцээ байсаар байна

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Насанжаргал эмчээс асуухад бидний илрүүлж байгаа түрхэц дэлхийн чадамжийн хаана явна вэ? Хангалттай гүйцэтгэлтэй хуурамч эерэг гарч байна гэдэг нь ямар байгаа гэсэн үг вэ? Ингэж үнэлж байгаа манай түвшинг хэлж өгөөч.</p> <p>Эхний илтгэгчээс асуухад ХӨСҮТ-ийн лавлагаа төвийн хүний нөөцийн чадамж ямархуу байгааг хэлж өгнө үү. Гэрээндээ суралцагчдын хугацааг хэрхэн зааж өгсөн бэ? Сургалтандаа хамрагдаад орон нутагтаа очиж ажиллаагүй 2 хүн байна гэнэ. Тэдний хариуцлагын тогтолцоог ЭМЯ-тай хамтран шийдвэрлэх боломж байгаа юу?</p>
ТБ	<p>Ц.Адъяахишиг: ГС-ийн санхүүжилтээр бэлтгэгдсэн 1 эмч хувиараа ажиллаж байна гэж бичжээ. Нэг эмч ТББ-д ажилладлаг юм байна. Энэ талаар тайлбарыг өгнө үү.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: Эхний илтгэгчээс тодруулах зүйл байна. БЗДХ-ын чиглэлээр ажиллах энэ сургалтын талаар сүрьеэгийнх шиг дүгнэн хэлэх хувь байна уу? Одоо бид хаана явж байна вэ? Цаашид хаа хүрэх вэ? Дутагдал нь арилж байгаа юмуу? Тэр талаар илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү.</p>
ХӨСҮТ	<p>Р.Дорждэрэм: Сүрьеэгийн бус чиглэлээр 3 эмч ажиллаж байгаагаас 1 нь сумын эмч, 1 нь чанарын менежер, нөгөө 1 нь тархвар судлаач хийж байна. ТББ-д ажиллаж байгаа 1 хүн маань анхнаасаа МСЭМХ-оос суралцсан бөгөөд тэндээ л ажилладаг.</p>
ХӨСҮТ	<p>Б.Цэцэгтуяа, СТА-ны эмч: Ерөнхийдөө манай лаборатори Японы сүрьеэ судлалын хүрээлэнд хянуулдаг. Өсгөврийн шинжилгээний хувьд улсын хэмжээнд хангалттай үнэлэгдсэн бөгөөд 98 хувиас дээш буюу хангалттай чанарын үнэлгээтэй гардаг. Улирал тутам явагддаг үнэлгээнд хамрагдан шаардлагатай тохиолдолд ур чадварын сургалтанд хамрагддаг.</p>
ХӨСҮТ	<p>О.Энхжаргал: Сургалтанд хамрагдсан эмч нарын гэрээг 3-5 жилээр хийсэн бөгөөд үүнээс 3 нь одоогоор амаржсаны амралттай байна. Мөн манай зарим эмч нарын хувьд нэг асуудал байгаа нь арьс судлал, халдвар судлалын үндсэн мэргэжил эзэмшсэн болохоор тухайн орон нутагтаа очоод орон тоо хүлээх эсвэл халдвартын болон арьсны эмчийн үүргийг хавсран гүйцэтгэж байна.</p> <p>ЭМС-ын 305-р тушаалаар орон нутагт 53 эмч ажиллах ёстой гэж үзсэн байхад 2018 онд 23 эмч ажиллаж байсан буюу 43% нь ажиллаж байсан. Тэгэхээр эдгээр 13 эмч сургагдсанаар 30% орчим хангагдсан. Дүүргүүдэд 31 эмч ажиллахаас 11 эмч ажиллаж байсан одоо 14 хүн ажиллах болсон.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: 2 жилийн хугацаатай сургалтыг богиносгон түргэсгэсэн сургалт зохион байгуулж байгаа нь хэр нийцтэй байгаа вэ?</p>
ЭМЯ	<p>Т.Энхзаяа: Энэ богино хугацааны сургалт бол цэвэр хэрэгцээн дээр суурилсан сургалт болж байгаа юм. Учир нь БЗДХ, сүрьеэгийн эмч нар дутагдалтай байсан болохоор энэ арга хэмжээг авсан. Гэхдээ үүнд онолын 10 сэдэв, семинарын 22 сэдэв, бие даалтын 4 сэдэв байгаа нь нийт судлах кредиттэйгээ дөхөж очиж байгаа гэсэн мэдээллийг бидэнд Анагаах Ухааны Их Сургуулиас өгсөн.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: Ямар ч хэрэгцээ шаардлагад тулгуурласан байсан бид богино хугацаанд сургаж байгаа нь бусдад их буруу жишиг тогтооно. Эрэлт хэрэгцээтэй байж болох боловч тэгш, шударга, хариуцлагатай байх бүхий л зарчмууд энд алдагдаж байна. Бусад 2 жилээр суралцаж байгаа эмч нарын эрх ашгийг маш их зөрчиж байж сургаж байхад эдгээр сургасан мэргэжилтнүүдээ яагаад ажиллуулж чадахгүй байгаа асуудлыг ЭМЯ-д тавьмаар байна. Учир нь ЭМЯ-д ҮЗЗ-ийн зүгээс зөвлөмжөө өгөх хэрэгтэй байна. Бид яг тухайн чиглэлээр ажиллуулах л гэж санхүүжилт болон богино хугацааны сургалтыг олон хууль, тушаал зөрчиж байж гаргасан. Гэтэл 13 хүний 2 хүний нэг нь хувиараа сурж байгаа бол тэр хүнийг богино хугацаанд сургах шаардлага байхгүй. Бид зарчимтай, шударга байх хэрэгтэй. Хэрэв сурсан бол улсын эрүүл мэндийн салбарт ажилла, үгүй</p>

	бол сурсан мөнгөө буцааж тушаа, таны тушаасан мөнгөөр бид дараагийн хүнийг сурган ажиллуулна гэдгийг шударга тавих хэрэгтэй. Бид ҮЗЗ-ийн Хяналтын хорооны хурлаар энэ асуудлыг дахин авч үзье гэж бодож байна. Женэкспертийн төхөөрөмжийг ДЭМБ-аас ч бас бидэнд нийлүүлсэн. Гэтэл бид энэхүү тоног төхөөрөмжөөр ганцхан сүрьеэг илрүүлээд байна. Бид нэмэлт өөр олон шинжилгээнүүдийг хийх боломжтой. Энэ талаар ч бас мэдээлэл өгч хамтарч ажиллаарай гэсэн саналтай байна.
ЭМЯ	Т.Энхзаяа: Мөнхжаргал гишүүнтэй санал нэг байна. Тэдгээр сургагдсан эмч мэргэжилтнүүдтэй ажиллах талаар би С.Амарзаяа мэргэжилтэнтэй ярилцах болно. Гэрээний асуудлыг давхар шалган яагаад улсын эмнэлэгт ажиллахгүй байгааг шалгаж үзнэ.

Харнулт

Шийдвэр:

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Гохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #3 Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай тайланг танилцуулах.
Асуулт хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)> үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Н.Сувд, Сүрьеэгийн хөтөлбөрийн үнэлгээний дотоодын зөвлөх; /Хавсралт №4/,

- Үнэлгээ эхлэхийн өмнөх судалгаа
 - Ярилцлага хийсэн газар, мэргэжилтэн
 - Улаанбаатар: ҮЗЗ (дарга, зохицуулагч), ХӨСҮТ (Тандалтын алба, Үндэсний лавлагаа лаборатори, эмийн агуулах, сүрьеэгийн амбулатори, хэвтэн эмчлүүлэх хэсэг), ЭМЯ (Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга), ТХН, LPA, ДЭМБ, төсөл хэрэгжүүлэгч нэгж: МУЗН + МСТН + МСЭМХ + МӨАУМХ + 429 хорих анги, Сонгинохайрхан дүүргийн сүрьеэгийн диспансер, эмийн сан
 - Дархан: Аймгийн сүрьеэгийн эмнэлэг, сум 1, өрхийн эмнэлэг 1
 - Ховд: Аймгийн сүрьеэгийн эмнэлэг, өрхийн эмч 1, эмийн сан 3
 - 80 гаруй хүнтэй ярилцав > 10 хэвтэн эмчлүүлэх, > 10 амбулатор, 2 фокус бүлэг ярилцлага 25 сүрьеэтэй өвчтөн, эрүүл мэндийн 10 ажилтаны 1 фокус груп ярилцлага
- Сүрьеэгийн шинэ тохиолдол 2015 онтой харьцуулахад 2016 онд 2,3 дахин өссөн.

(100,000 хүн амд 183-аас 248 болсон иймээс жилд 14,000 сүрьеэтэй өвчтөн)

Сүрьеэгийн бүртгэл 2015 оноос хойш буурч байна (-20%)

Сүрьеэгийн эмчилгээний цар хүрээ (тохиолдлыг илрүүлэх түвшин) 2018 онд 80-аас 29% болж буурсан.

2015 онтой харьцуулахад 2016 онд олон эм/рифампинд тэсвэртэй сүрьеэ (M/RR TB)-гийн тархалт 3,8

дахин ихэссэн тооцоо байна (Сүрьеэгийн шинэ тохиолдлын дунд 5.4% vs 1.4% M/RRTB) иймээс жилд 720 M/RR TB байгаа гэсэн судалгаа байна.

2018 онд MDR-TB эмчилгээний цар хүрээ (тохиолдлыг илрүүлэх түвшин) 27% болж буурсан.

Нийт сүрьеэтэй тохиолдлын 70% нь санхүүгийн хүнд дарамтанд орсон байна.

- Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2017-2020-г 2017 онд ЭМЯ баталсан. Үүнд сүрьеэ орж байна
 - Өвчтөн төвтэй тусламж үйлчилгээг дэмжих
 - Сүрьеэгийн асуудлаар тулгарч буй бэрхшээл, тэргүүлэх чиглэл, төсөв, сүрьеэгүй болох болон стратегийн талаар дурдаагүй
- Сүрьеэгийн шинж удирдамжийг боловсруулж байгаа
 - Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээний богино хугацааны горим, амбулатороор эмчлүүлэх, латент сүрьеэгийн халдвар, халдвар хамгаалал
 - Олон эмэнд дасалтай сүрьеэгийн эмийн амаар уух горим, TB & MDR/TB амбулатороор эмчлүүлэх, хянуулах, Цээжний рентген зураг – жен эксперт (GX)-ийг сайн таниулах

TB-HIV Шилжилтийн төлөвлөгөө зэрэг хийгдэх, төсөвт анхаарах гэхдээ энэ нь GF төсөв хуваарилалтанд нөлөөлөхгүй

Нийт санхүүжилтийн >80% Засгийн газар (ЗГ)-аас

- 2015 оноос хойш ЗГ-ын санхүүжилт ихсэж байгаа (+20% in 2017-18)
- 2018 онд нийт санхүүжилтийн 70% -ийг ЗГ-аас (Сүүлийн GF грантийн хүсэлт дээр)
- Санхүүжилтийг хэрхэн зарцуулсан тухай ойлголт тодорхой буй байна.
- Нийт 6 сая \$ -оос 2,5 сая \$ (40%)-ийг өвчтөнд менежмент (patient support) зарцуулж байна гэхдээ өвчтөн, өвчтөний гэр бүлийн 70% санхүүгийн дарамтанд орж байна.

Өрхийн эмнэлэг: 2019 оны нийт илэрсэн тохиолдлын 33% нь идэвхигүй илрүүлгээр (2018 онд 31%)

ACF (Идэвхитэй илрүүлэг): 2018 онд бүртгэгдсэн нийт сүрьеэгийн 11%

Хүрсэн амжилт

- 2017 онтой харьцуулбал 2018 онд Монгол улсаас оруулах хөрөнгө оруулалт/төсөв ихсэж байгаа нь улс төрийн оролцоо ихэссэн (+20%) + Орон нутгийн засаг захиргааны оролцоо (2018 оны 11-р сар Улаанбаатарын тунхаглал) + цалингийн өсөлт
- Үнэлгээний үеэр өндөр идэвхитэй сүрьеэгийн төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан
- Өндөр гүйцэтгэлтэй үзүүлэлттэй (Сүрьеэ, олон эмэнд дасалтай сүрьеэгийн тохиолдлоос бусад)
- GF-ийн санхүүжилтийн хэрэглээ өндөр (>95%) – B1 түвшин
- Сүрьеэгийн найдвартай цаасанд суурилсан бүртгэлийн тогтолцоо
- Сүрьеэгийн хавтал + орон гэргүй хүмүүс + олон төрлийн өвчлөл (ЧШ, даралт ихсэх өвчин, уушгины эрүүл мэнд)-ийн хувьд 2016 оноос идэвхигүй илрүүлгээс идэвхитэй илрүүлэг рүү шилжиж байна
- 2019 оны 1-р улиралд GX-ийн хэрэглээний хувь 30% -иас 53% өссөн.
- Эмчилгээний үр дүн өндөр
- Өрхийн эмнэлгээс сүрьеэгийн эмч рүү илгээх байдал сайжирсан (уулзах үед ажиглагдсан)
- 9 сарын турш 15 сүрьеэгийн эмч бэлтгэж байна
- ХӨСҮТ нь ТББ-тай сайн хамтран ажилладаг

Тулгарч буй бэрхшээл

- GF-д дараагийн санхүүжилт хүсэх үйл ажиллагаа тодорхойгүй. Үүнд судалгаа хийх, үндэсний стратегийн хөтөлбөрийг бусад халдварт өвчинтэй хамт хийх эсвэл дангаар хийх, санхүүжилт хүсэх өргөдөл
- Шилжилтийн төлөвлөгөө боловсруулж байгаа
- Цээжний рентген машины хэрэглээ нь идэвхитэй илрүүлэг хийхэд хангалттай бус байна. Эрсдэлт бүлгийн хүн амын дунд хангалттай бус илрүүлэг хийсэн. Идэвхитэй илрүүлгээр нийт сүрьеэтэй тохиолдлын 11%
- Сүрьеэгийн илэрсэн бүх тохиолдолд DOT хийснээс нөөцийг идэвхитэй илрүүлэлт рүү чиглүүлэхгүй байна (Энэ нь сүрьеэгүй болох стратегийн бичиг баримттай нийцэхгүй байна).
- Оношийн алгоритм нь системтэй бүх өвчтөнд хэрэглэхгүйгээс шинж тэмдэг дээр суурилсан онош байна. (СХР хэрэглээ бага)
- Сүрьеэгийн удирдамж амбулатороор эмчлэх зарчмыг хэрэгжүүлэхгүй байна.
- Олон эмэнд дасалтай сүрьеэгийн 9 сарын богино горимын эмчилгээнд тариагаар хэрэглэх нь бага

- Хүүхдийн дундах LTBI –ийн менежмент бага (зөвхөн арьсны сорил TST+) мөн СҮрьеэ/ДОХ
- Халдвар хамгаалал: HN95/FFP2 маск, эрүүл мэндийн ажилтаны дундах сүрьеэгийн илрүүлэг, бүртгэлийн мэдээ байхгүй. Үнэлгээр очсон 3 газар агааржуулалтын систем үгүй
- GX картрижийн нөөц бага, хангагч нь хэт их үнэ хэлсэнээс калибраци хийгдээгүй (450\$-ийн оронд 4000\$)
- Гадуурхал байсаар байна: тухайлбал фокус груп ярилцлагын үеэр 2 хүн ажилгүй болсон

ЭМЯ-ХӨСҮТ-тэй ярилцаж, зөвшилцсөний дагуу дараах зөвлөмж гаргалаа.

1. 2019 оны төгсгөл гэхэд сүрьеэгийн байдалд дүн шинжилгээ хийж, судалж дуусгах
2. Сүрьеэгийн эсвэл халдварт өвчний үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулах (NSP 2021-2023 or 2025) ДЭМБ-ын техникийн дэмжлэг авах үүнд
 - a. Судалгаа хийхэд гарсан бэрхшээлийн байдал
 - b. Сүрьеэг таслан зогсоох стратеги
 - c. CXR-GX оношлогооны алгоритмыг хэрэглэн идэвхитэй илрүүлгийг хийх
 - d. Төр, олон нийтийн түншлэлээр дамжуулан эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн дунд болон сүрьеэгийн холбоо, одоогийн төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд дээр идэвхитэй илрүүлэг хийх
 - e. Дэлгэрэнгүй санхүүгийн төлөвлөлт
3. 2020 оны 2 сар гэхэд GF-аас санхүүжилт хүсэх. Үүнийг ДЭМБ-ын техникийн дэмжлэгтэй хийх (техникийн дэмжлэгийн хүсэлтийг ДЭМБ-д гаргах)
4. 2020 оны 2 сард дуусган, батлуулахын тулд Сүрьеэ/ДОХ шилжилтийн төлөвлөгөөг дуусгаж ҮЗЗ-р батлуулах
 - Сүрьеэгийн удирдамжийг шинэчлэн засварлан батлуулах, ЭМЯ-ны тушаал
 - Тусгай бүлэгт DOT-г хэрэгжүүлэх (ж нь орон гэргүй, хорт зуршилтай бүлэг гэх мэт)
 - NNS (Number needed to screen) Үндэслэн идэвхтэй илрүүлгийн алгоритмыг хийх
 - MDR богино хугацааны амаар уух горим
5. GX калибраци болон засвар үйлчилгээнд анхаарах, агааржуулалтын системтэй байх (450\$/ жил)
6. ҮЗЗ. 2020 оны 03/23-нд гэхэд GF-аас санхүүжилт хүсэх үйл ажиллагааны нарийн төлөвлөгөө гаргах
7. ЭМЯ нь цаашид санхүүжилтийн хэмжээг хэмжээг ихэсгэх, зарцуулалтыг хянах тогтолцоог бий болгох.
8. NSP болон GF-ийн санхүүгийн хүсэлт гаргах үйл ажиллагааны бэлтгэлд ДЭМБ-аас дэмжлэг хүсэх

М.Нандинчимэг, ХДХВ/ДОХ-ын хөтөлбөрийн үнэлгээний дотоодын зөвлөх, /Хавсралт №5/

Зорилго: өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ямар арга хэмжээ, хөрөнгө оруулалт нь тухайлсан улс орнуудын хувьд ХДХВ/Сүрьеэ/Хумхаа өвчинд чиглэсэн хариу арга хэмжээг тогтвортойгоор авч хэрэгжүүлэхэд нь хэрхэн дэмжлэг болж байгааг үнэлэх түүнчлэн Глобаль сангийн хөрөнгө оруулалтын үр нөлөө, үр дүнг үнэлэх зорилготой.

Монгол Улс дах ХДХВ халдварын тархалтын байдалтай холбоотой анхаарах асуудлууд
(Глобаль сангаас санал болгосон чиглэлүүд)

- ЭБЭ хөтөлбөр – ЭБЭ нарын дунд ХДХВ-ийн халдвар илэрүүлэх шинжилгээтэй холбоотой тулгарч буй гол асуудлууд. Үйлчилгээ авч байгаа ЭБЭ-ийн тоо хэдий олон байгаа ч шинжилгээний хамрах хүрээ хангалтгүй
- ЭБҮ хөтөлбөр – Чанартай тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эсэх? Хүрч очсон болон шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо өндөр байгаа хэдий ч тохирсон, чанартай тусламж үйлчилгээ үзүүлж байгаа талаар үзүүлэлт хомс
- Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад эрүүл мэнд болон олон нийтийн байгууллагуудын харилцан уялдаа хамтын ажиллагаа. Амжилттай хэрэгжиж байгаа мөн цаашид сайжруулах шаардлагатай үйл ажиллагаа
- Төвлөрсөн хот суурингаас гадна орших зорилтот олон нийтийн хамрах хүрээг хэрхэн нэмэгдүүлэх

Зорилт 1: Үндэсний стратегийн хэрэгжилт

- Монгол улс дах халдварын тархалтын онцлогийг харгалзсан улмаар зорилтот олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжүүлж байна.
- ХДХВ болон БЗХӨ тухайлбал тэмбүү өвчинтэй тэмцэхэд чиглэсэн нэгдсэн, цогц арга хэмжээ авч байна
- ХӨСҮТ нь үндэсний хэмжээнд, түүнчлэн аймаг, орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэргэжил арга, зүйгээр хангах, чадавхжуулах сургаж байна.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа тогтвортойгоор сайжирж байна.
- Дархан Уул аймаг дах төрийн байгууллага орон нутгийн ТББ-д үр дүнтэй хамтран ажилласан түншлэлийн сайн жишээ (ЭБҮ-тай ажиллагч ТББ нь эмнэлгийн байранд үнэ төлбөргүйгээр сургалт, бусад үйл

ажиллагаа зохион байгуулах өрөө, тасалгаагаар хангагдсан)

- РВЭЭ-ний худалдан авах үйл ажиллагаа тогтмолжсон.

Зорилт 2: Тусламж үйлчилгээ үзүүлж буй байдал

- Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс өвчтөн/үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээг тууштайгаар үзүүлж буй байдал, тусламж үйлчилгээг цогц хэлбэрээр үзүүлэх зорилт
- ТББ-уудад зорилтот олон нийтэд үзүүлж буй тусламж үйлчилгээ нь хүний эрхэд суурилсан хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа
- Үйлчлүүлэгчийн нийгэм сэтгэл зүйн онцлог хэрэгцээг анхаарсан
- Үйлчлүүлэгчээс тусламж үйлчилгээтэй холбоотой эерэг дүгнэлт өгч байна.
- Мэдээлэл сурталчилгааг хүргэх цар хүрээ, зорилтот олон нийтийг шинжилгээнд хамруулах (ЭБЭ, ЭБҮ)
- Трансжендер эмэгтэйчүүдийн хөтөлбөрт хамрагдалт
- Шинээр оношлогдсон өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ, холбон зуучлах үйл явц тогтмол, тогтсон хугацаанд нь хийгдэж байна.
- РВЭЭ-нд хамрагдалт нь олон улсын зорилтот түвшинг хангасан
- Эмчилгээнд тогтвортой хамрагдаж байгаа хувь (сүүлийн 12 сарын байдлаар 91%) эмчилгээний чанар, үр дүн (91%)

Зорилт 3: Мэдээлэл

- хөтөлбөр зохицуулах нэгж нь үйл ажиллагааны үр дүнг тогтмол хянах, тайлагнах, мэдээлэх тогтолцоо, аргачлалыг (Unified UIC) хэрэгжүүлж байна.
- Өвчтөний талаар мэдээллийг бүрэн, цогц хэлбэрээр цуглуулж ашигладаг.
- Стратегийн ач холбогдол бүхий өндөр түвшний мэдээллүүдийг нэгтгэн авах боломжтой (IBBS, mapping, NASA, SARA)
- Тусламж үйлчилгээний шатлал бүрт хийгдэж буй үйлчилгээг харуулсан мэдээллийн ашиглалт сайн (ТББ, сум, аймаг, үндэсний хэмжээнд)
- Хувь хүний мэдээлэл, нууцлал, хадгалалт сайн.

Анхаарч сайжруулах чиглэлүүд:

Зорилт 1: Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

- ХДХВ/ДОХ-ын чиглэлээр хариу арга хэмжээг авахад үндэсний хэмжээний удирдлага, манлайллын багийн тогтвортой байдал
- Тогтвортой байдал болон шилжилтийн төлөвлөгөөг боловсруулах шаардлага, хэрэгцээ
 - Аймаг, орон нутгийн түвшинд ТББ-ын тогтвортой үйл ажиллагааг хангахад Эрүүл мэндийн яамны зүгээс тодорхой чиглэл, дэмжлэгийг үзүүлэх
- ХДХВ/ДОХ-ын халдвар, тархалтыг бууруулахад чиглэсэн дараагийн стратеги боловсруулахтай холбоотой аргачлал, чиглэлийг тодорхой болгох (Бэлгийн замын бусад халдварт өвчнүүдийн хамт багтаасан нэгдсэн стратеги гэх мэт)
- Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэх үйл ажиллагааны тодорхой хэсгүүдийг сайжруулж, бэхжүүлэх
 - Шинжилгээний урвалж, БЗХӨ-ний антибиотик, ХДХВ-ийн халдвар илэрүүлэх шинжилгээний тест, холбогдох хэрэгслүүдийн найдвартай нийлүүлэлт, хүртээмжийн асуудал
 - Хэрэглэгчийн шаардлага, хэрэгцээнд нийцсэн хамгаалах хэрэгслүүд (жишээ нь ЭБҮ нарт тараагддаг бэлгэвч)
- Хүний эрхт-суурилсан стратеги, мессеж, бодлогод анхаарч бэхжүүлэх
 - Нийгэмд иргэдэд айдас төрүүлэх хэлбэрээр мэдээлэл хүргэхээс зайлсхийх цогц арга хэмжээ, сөрөг хандлага буруу ойлголтыг бууруулах нөлөөллийн ажил хэрэгжүүлэх U=U ойлголтыг түлхүү өгөх
 - Ажил олгогчийн шаардлагаар хийгддэг шинжилгээний явцад ажилтны хувийн мэдээллийг нууцыг хамгаалах, (халдварын статусыг ажил олгогчтой хуваалцахгүй, мэдээлэхгүй байх)
 - Халдвартай амьдарч буй иргэдийн хөдөлмөр эрхлэх эрхийн хамгааллын асуудал, шаардлагатай тохиолдол бүрт нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг тогтолцоог бүрдүүлэх

Зорилт 2: Тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлд

- Олон нийтэд суурилсан шинжилгээний арга хэлбэрийг танилцуулах (эмнэлгийн мэргэжлийн бус хүрч очих ажилтнууд явуулын OralQuick аргыг ашиглах) нэвтрүүлэх
- Удирдамжинд тусгагдсан үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хийгдэх шинжилгээ, зөвлөгөө өгөх явцыг бэхжүүлэх
- Халдварын өндөр эрсдэлтэй залуучуудын дунд тэдэнд ээлтэй, тохирсон аргачлал бүхий халдвараас урьдчилан сэргийлэх, шинжилгээнд хамруулах залуучуудад ээлтэй төв (асрах газар, дотуур байр гм)
- Хавьтал илэрүүлэх шинэлэг арга хэлбэрийг ашиглах
- Өвчтөнд ээлтэй эмнэлгийн үйлчилгээний арга хэлбэрийг сайжруулах (жишээ нь CD4 and вирусын ачааллын шинжилгээг хийлгэх зорилгоор аймаг, орон нутгаас Улаанбаатарт ирэх шаардлага гарч байна.)
- ХДХВ/ДОХ-ын харилцан ялгаатай эмчилгээ, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх (жишээ нь зарим тогтвортой өвчнүүдэд эмийг 3-6 сараар)
- ХДХВ/ДОХ нь архаг өвчин болохын хувьд тухайн өвчний менежментийг сайжруулах
- Илэрүүлэлт шинжилгээ болон эмчилгээтэй холбоотой үүрэг хариуцлагын ялгааг анхаарч үзэх
- Клиник/эмнэл зүйн хяналт хийх үндэсний хэмжээнд ашиглах аргачлалуудыг стандартчлах
- Кейс менежментэд салбар дотор хамтын ажиллагаа, нөөцийг ашиглах, СДЗШ-ний төвд ажиллаж байгаа эмнэлгийн дунд мэргэжилтний зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэх.
- Өвчтөнд нийгэм, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, зөвлөгөөг мэргэжлийн сэтгэл зүйч өгч байгаа эсэх
- Өвчтөний нууц, хувийн мэдээлэл, халдвар хамгаалалтай холбоотой эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн дунд дах буруу ойлголтыг арилгах
- Анхан шатны тусламж үйлчилгээ болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хүний нөөц болон хамтын ажиллагааны бусад боломжуудыг эрж хайх

Зорилт 3. Мэдээлэл

- Тусламж үйлчилгээ анхан шатлал, байгууллагад олон тооны давхацсан мэдээлэл бүхий тайлангийн олон маягт ашиглан тайлагнах шаардлага гарч байна.
- Зорилтот олон нийтийг бүрэн хянаж илэрүүлэлт хийх боломж
- ХДХВ-ийн халдварын тусдаа тайлагнах тогтолцоо, түүний тогтвортой байдал
- Яамны түвшинд холбогдох бодлого боловсруулах хэрэгцээнд ашиглах шаардлагатай мэдээллийн урсац хангалтгүй
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад хийгдэх хавьтал илэрүүлэлт, тайлагнах

Зөвлөмж

- Стратеги, бодлогын түвшинд БЗХӨ, ХДХВ/ДОХ-ын хөтөлбөрийг цогц хэлбэрээр хэрэгжүүлэх
- ЭБЭ – хавьтал илэрүүлэх мэдээлэх шинэлэг арга, аргачлалыг ашиглах
- ЭБҮ- үе тэнгийнхнээр хийгдэх шинжилгээ болон өөрөө өөрийгөө шинжлэх аргачлал, тохирсон хамгаалах хэрэгсэл, ЭБҮ нарын талаар нийтлэг ойлголт (ивээн тэтгэгчтэй бэлгийн харилцаа, эрсдэл бүхий залуучууд)
- Хүний нөөцийн бүрдүүлэлт, тогтвортой байдал, чадавхжуулах чиглэлээрх сургалтын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- Тусламж үйлчилгээнд холбон зуучлах – үйлчлүүлэгчид ээлтэй кейс менежмент, өвчтөнд ирэх ачааллыг багасгах үүднээс ялгаатай тусламж үйлчилгээ үзүүлэх
- Тусламж үйлчилгээг Улаанбаатар хот ба бусад томоохон хотуудаас цааш өргөжүүлэн тэлэх зорилгоор цахимаар хүрч очих үйлчилгээг үзүүлэх, нүүдлийн зөвлөгөө, шинжилгээний үйлчилгээ (IBBS-ийн хэрэгжилтээс суралцсан сургамж, үйлчлүүлэгчийн санаачлага бүхий зөвлөгөө, шинжилгээ, хамтрагчийг мэдээлэх шинэ арга, аргачлал гэх зэрэг)

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Y33-AA	Б.Оюундарь: Гишүүд маань үнэлгээний талаар танилцуулж байгаад гайхаж байж магадгүй. Тиймээс та бүхэндээ тайлбарыг өгөх үүднээс танилцуулахад өнгөрсөн хугацаанд хөтөлбөрт үнэлгээ хийхдээ СОНА-аар дамжуулан үнэлгээг хийдэг байсан бол энэ жилээс хөндлөнгийн байгууллагатай хамтран
--------	--

	улс орнуудад хөтөлбөрийн үнэлгээг хийж байна. Хөтөлбөрийн үнэлгээнээс гарсан дүгнэлт дараагийн 3 жил хэрэгжүүлэх шинэ төсөлтэй шууд холбогдох учиртай. Өнгөрсөн сард 2 долоо хоногийн турш хийсэн үнэлгээний хувьд бүхий л оролцогч байгууллагууд оролцсон бөгөөд ҮЗЗ-ийн даргатай бас уулзсан. Та бүхэнд асуух асуулт байвал мэргэжлийн хариуцсан хүмүүс нь давхар хариултаа өгөөд явах байх гэж бодож байна.
ТБ	Т.Энхзаяа: “Яамны түвшинд холбогдох бодлого боловсруулах хэрэгцээнд ашиглах шаардлагатай мэдээллийн урсац хангалтгүй” гэж үзсэн байна энэ талаар дэлгэрэнгүй тайлбарыг өгнө үү. Мөн “Анхан шатны тусламж үйлчилгээ болон хувийн хэвшлийн байгууллага хоорондын хүний нөөц болон хамтын ажиллагааны бусад боломжуудыг эрж хайх.” гэсэн байна энэ тал дээр ямар арга хэмжээ авч ажиллуулах тал дээр бидэнд зөвлөгөө өгнө үү.
Олон нийт	Н.Туяацэцэг: Урдчилан сэргийлэх сурталчилгаа ямар түвшинд байна гэж үзсэн бэ? Төсөв хөрөнгө нь чамлалттай гэж үзэж байсан уу? Хангалттай гэж үзэж байсан уу? Энэ талаар тайлбар өгнө үү.
ТБ	Ж.Мөнхжаргал: Ерөнхийдөө Нийгмийн Эрүүл мэндийн асуудалтай холбох бололцоо байгаа юу? Бид энэ ажлын хүрээнд их мөнгө зарцуулсан өдий зэргийн амжилтанд хүрэлгүй яах вэ? Гэж бодоход бид арай өөрөөр ажилласан гэж бодоход эдгээр өвчлөлд илрүүлж чадахгүй байгаа өвчлөлийг илрүүлэх байждээ гэсэн бодол байсан боловч гэж бодож байна. Сүрьеэгийн үнэлгээн дээр асуухад 4 хуудас дээр сүрьеэгийн бүх хэлбэрийг хэвтэн эмчлүүлж эдгээрэд байна гэдэг дээр сүрхий анхаарал хандуулсан байна. Тэгвэл эцэг эх, хайрт ханиасаа авсан олон эмэнд болон маш олон эмэнд дасалтай Сүрьеэг яах ёстой талаар зөвлөмжиндөө тусгаарай. Түүнчлэн ДОХ-той хүмүүсийн нууцлалыг маш сайн хангаж байна гээд байна. Төр эдгээр хүмүүсийнхээ нууцыг хамгаалж чадахгүй сандарч байгаа. Тэгэхээр энэ талаар зөвлөмжийг бас тусгаж өгөөч ээ гэсэн саналыг өгье.
ОУ зөвлөх	М.Нандинцэцэг: Шийдвэр гаргахад олон талаас харсан мэдээлэл дутмаг байсан. Аливаа мэдээлэл гарсан ч олон талт харилцаагаар зохицуулах байдал дутмаг. Байгууллагуудад нэгдсэн мэдээллийн бааз байхгүй ялангуяа бодлого боловсруулах түвшинд олон талын мэдээллийг татаж авах боломж бага гэдэг утгаараа олон талын мэдээлэл авах мэдээллийн гарцууд хэрэгтэй байна. Тиймээс мэдээллүүдийг олон талаас цуглуулаагүй байдал ажиглагдсан. Тэгэхээр би энэ талаас нь зөвлөгөөний багийн ахлагчдаа мэдээллээд сайн туршлага байвал зөвлөмжиндөө оруулаач гэсэн саналыг уламжилна. Анхан шатны байгууллага гэдэгт манай 2 зөвлөх Канад болон Америкт яг тухайн чиглэлээр 17-20 жил ажилласан туршлагатай байсан. Тэдгээрийн хувьд эдгээр үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаараа хөөцөлдүүлээд ТББ бол тодорхой хэмжээгээр хувийн хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулдаг байна. Энэ талаарх мэдээллээ тайландаа тусган ирүүлэх саналыг хүргүүлье.
Зөвлөмж:	
Шийдвэр:	
Хөтөлбөр #4	Глобаль сангийн үйл ажиллагатай холбоотой Эрүүл мэндийн сайдын А/460, А/511 тоот тушаалуудын хэрэгжилтийг танилцуулах; 2021-2023 онуудад хэрэгжүүлэх Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах Асуулт хариулт
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.	
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>	Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй	
С.Амарзаяа, ЭМЯ, НЭМГ-ын мэргэжилтэн: Глобаль сангийн үйл ажиллагатай холбоотой Эрүүл мэндийн сайдын А/460, А/511 тоот тушаалуудын хэрэгжилтийг танилцууллаа. /Хавсралт 5/	
ЭМСайдын 2019 оны 460 дугаар тушаал	
- ХДХВ, ДОХ, Сүрьеэгийн тархалтыг бууруулах үйл ажиллагааны өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, удирдамж	
- ЭМЯ-ны удирдлагын зөвлөлд 2019 оны 12 дугаар сард багтаан танилцуулах	

Ажлын хэсгийн дарга ЭМЯ НЭМГ-ын дарга

- Төлөвлөгөө боловсруулах багийн Ажлын төлөвлөгөө гарсан
- ХДХВ, БЗДХ, сүрьеэгээс сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах багууд ажиллаж, төлөвлөгөөний төсөл бэлэн болсон
- Мэргэжлийн байгууллага, олон улсын байгууллагаас санал авч байна
- Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтнүүдээс санал авахаар бэлтгэж байна

ЭМСайдын 2019 оны 511 дүгээр тушаал

- ХДХВ, ДОХ, БЗДХ, Сүрьеэгээс сэргийлэх, тархалтыг бууруулах хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөний Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, удирдамж
- ХДХВ, ДОХ, БЗДХ, Сүрьеэгээс сэргийлэх, тархалтыг бууруулах хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах төлөвлөгөө, 2020 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулах
 - Удирдах зөвлөлийн дарга ЭМ-ийн дэд сайд
 - Удирдах зөвлөлийн хурал: 2019-11-22
 - ХДХВ, БЗДХ болон сүрьеэгээс сэргийлэх тархалтыг бууруулах арга хэмжээний нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах багт ажиллах дотоодын зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах, зөвлөх үйлчилгээний шалгуурыг боловсруулахыг ХӨСҮТ-д үүрэг болгосон.

Цаашид авах арга хэмжээ

- Үнэлгээний багт ажиллах зөвлөхийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг түргэсгэх
- Төлөвлөгөөний төсөлд санал авах, өгөх ажлыг яаралтай зохион байгуулах, хэлэлцүүлэх
- Санал тусгагдсан байдалд дахин хяналт хийх

Б.Оюундарь: 2021-2023 онуудад хэрэгжүүлэх Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах: Түүрүүн танилцуулсан ЭМС-ын 2 тушаалын хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна. Түүнчлэн ҮЗЗ-ийн дүрмийн 12-т зааснаар “Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх төсөл боловсруулах үйл явц, батлагдсан төслийн хэрэгжилт болон хэрэгжээд дуусч байгаа төслийн үйл явцад ерөнхий хяналт тавьж, хөтөлбөрийн түншлэл болон олон салбар, чиглэлийн оролцоог дэмжих үндэсний зөвшилцлийн багийн үүрэг гүйцэтгэх бөгөөд ил тод шийдвэрээ гаргах;

“Үндэсний хэмжээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт болон стратегийн саналыг нэгтгэж, Глобаль санд хүсэлт тавих;” үүрэгтэй оролцдог.

Өнгөрсөн сард бүсийн менежер хүрэлцэн ирэхдээ ҮЗЗ-ийн дарга, дэд дарга нартай уулзахдаа дараагийн 3 жилийн санхүүжилтын хүсэлт бэлтгэх, үйл ажиллагааны талаар танилцуулсан. Дээрээс нь ГС-аас баталсан ҮЗЗ-ийн төслийг өргөн барих хугацааг зарласан. Монгол Улсад одоогийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хугацаа дуусахаас өмнө дараагийн санхүүжилтийн хүсэлтийг 2020 оны эхний хяналтын үед ирүүлэхийг зөвлөсөн. Улмаар 2020 оны 4-р сарын 27-ноос 5-р сарын 2-ны өдрийн хооронд Техникийн Хяналтын Хэлэлцүүлэгт хөтөлбөрөө хянуулахын тулд материал ирүүлэх сүүлийн хугацаа нь 2020 оны 3-р сарын 23-ны өдөр байх болно. Тэгэхээр бид Ажлын хэсгээ байгуулаад төлөвлөгөөгөө боловсруулаад 2020 оны 03 сар гэхэд ГС-д санхүүжилтын хүсэлтээ өргөн барих үүрэгтэй байна. ҮЗЗ-ийн ажлын албанаас энэхүү төлөвлөгөөг та бүхэнд урдчилан тараасан байгаа бөгөөд голлон анхаарах зүйл нь өнөөдрийн хурлаар дараагийн 3 жилийн төслийг боловсруулах төлөвлөгөөг батална гэж найдаж байна. Дээрээс нь үндэсний хэмжээний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй байгаа бөгөөд 12 сарын дундуур ГС-аас ямар хэмжээний санхүүжилт хуваарилагдсан талаар ҮЗЗ-д мэдэгдсэний дараа буюу 1 сарын 09-нд эхний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахаар энэ төлөвлөгөөнд оруулсан байна.

2 дахь зөвлөлдөх уулзалтыг 02 сарын 20-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн. Учир нь бүсийн менежер тус долоо хоногт Монгол улсад ирж ажиллах тул техникийн дэмжлэг авах зорилгоор хурлыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Тэгэхээр энэ төлөвлөгөөг та бүхэн харж саналаа хэлээд баталгаажуулж өгнө үү.

Хэлэлцэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ДЭМБ **П.Анужаяа:** Өнөөдөр танилцуулагдсан бүхий л мэдээлэл болон 2 төслийн үнэлгээний талаар мэдээлэл өгсөн та бүхэндээ баярлалаа. ГСанд төслийн эхийг 2020 оны 03 сарын 23-нд өргөн барихаар хугацаагаа тогтлоо гэж ойлгож байна.

Энд танилцуулсан ажлын төлөвлөгөөг харахад 1.4 дээр байгаа Техникийн дэмжлэг авах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох гэсэн үйл ажиллагаа байгаа нь Үндэсний болон олон улсын зөвлөхийг авч ажиллуулах хэрэгцээ шаардлагатай байгаа гэдгийг харуулж байгаа тул ДЭМБ-ын зүгээс 12 сарын 23-ны долоо хоногт энэ талаар хуралдан эцсийн шийдвэрийг хүргэх болно гэдгээ хэлэх байна. Мөн 2 долоо хоногийн дараа бид сүрьеэгийн зөвлөхүүдэд өнөөдрийн хурлын мэдээллийг хүргэнэ. Үүнд ҮХА төсөл бичихэд сүрьеэ болон ДОХ дээр төсөл бичихэд дэмжлэг өгөх шаардлагатай эсэх тал дээр

	миний зүгээс мэдээлэл өгөх шаардлагатай байгаа.
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: ГСан болон ДЭМБ-ын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд гадны зөвлөхийн дэмжлэг үзүүлэхээр хамтран ажиллах зохицуулалт байдаг. Дараагийн 3 жилийн төслийг боловсруулах гадны зөвлөхийн санхүүжилтыг ДЭМБ-аас санхүүжүүлэх боломжтой юм байна гэж би ойлголоо.</p> <p>Өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулахад мөн гадна, дотны 2 зөвлөх ажиллуулах байгаа. ЭМС-ын тушаалаар баталсан Өргөтгөсөн болон Шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулах ажил бол ГС-ийн төслийг боловсруулах ажилтай салшгүй холбоотой.</p> <p>Нэмэлт мэдээлэл болгох үүднээс хэлэхэд ГС-аас өнгөрсөн 10 сард хөрөнгө босгох үйл ажиллагаа зохион байгуулахад 14 тэрбум ам.доллар босгохоор зорин ажиллаж байсан бол 14,2 тэрбум ам.доллар босгосон. Ерөнхийдөө ГС-аас эрүүл мэндийн чиглэлээр босгосон хамгийн том санхүүжилт гэж үзэж байгаа юм билээ. Тэгэхээр Монгол Улсаас ажлын хэсгээ байгуулан ажиллана гэж найдаж байна. Тиймээс энэ талын ажлыг зохион байгуулж эртнээс бэлтгэх шаардлагатай байгаа юм.</p>
ЭМЯ-УХА	<p>Б.Цогтбаатар: Энэ асуудалтай холбоотойгоор манай улсыг хариуцсан сангийн менежерээс өчигдөр захидал ирсэн. Тус захидалдаа өмнө дурьдсанчлан, бид 2019 оны 12 дугаар сард Монгол Улсад хуваарилагдах санхүүжилтын захидлыг илгээхээр төлөвлөж байна. Мөн захидалд санхүүжилтийн хүсэлтэд ашиглах ҮЗЗ-ийн өргөдлийн төрлийг багтаасан тодорхой мэдээлэл агуулсан байсан. Монгол Улсад одоогийн хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хугацаа дуусахаас өмнө дараагийн санхүүжилтийн хүсэлтийг 2020 оны эхний хяналтын үед ирүүлэхийг зөвлөсөн бөгөөд ингэхийн тулд холбогдох Үндэсний стратеги төлөвлөгөөг 2019 оны 12-р сард эцэслэх нь чухал ач холбогдолтой гэдэг мэдээллүүдийг өгөхийн хажуугаар биднээс бас хариу шаардсан захидлыг ирүүлсэн байна.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: ЭМЯ-ны зүгээс энэхүү өргөтгөсөн төлөвлөгөөг хийхэд хугацаандаа амжина гэж бодож байна уу? Энэ ажлын хэсэгт ҮЗЗ-ээс хэдэн гишүүн байгаа билээ.</p>
ЭМЯ-НЭМГ	<p>С.Амарзаяа: Өргөтгөсөн төлөвлөгөөний ажил ерөнхийдөө болж байгаа. Одоо шилжилтийн үеийн төлөвлөгөөг боловсруулах ажилдаа ороод явж байна. Ерөнхийдөө эдгээр 2 төлөвлөгөөний ажлыг зэрэг боловсруулаад дээрээс нь төсөл бичих үйл ажиллагааг зэрэг хийж байсан нь дээр юм байна. Тэгэхгүйгээр цаг хугацааны хувьд давчуу байна гэж ярилцаад байж байна. Тэгэхээр дараа долоо хоногоос эрчимтэй ажиллаад явах болно. Манай энэ ажлыг голлон зохион байгуулж байгаа газар бол ХЗН, ХӨСҮТ байгаа.</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: Өргөтгөсөн төлөвлөгөөг 12 сардаа багтаан дуусгаарай гэсэн шалтгаан нь ГС-аас улс орнуудад санхүүжилт олгохдоо тухайн улс орны үндэсний хөтөлбөрт тулгуурлан шийдвэрлэдэг. Монгол улсын хувьд Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2020 онд дуусах тул 2021-2023 хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг боловсруулахад ямар нэг өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй байгаа тул бодлогын баримт бичгийг боловсруулж эхэлсэн. Тэгэхээр 12 сард ГС-аас МУ-д санхүүжилтын хуваарилалтыг ирүүлмэгц тэр бодлогын баримт бичигт тулгуурлан ажлаа хийгээд явах учиртай.</p>
ХЗН	<p>Н.Цогзолмаа: ХЗН-ээс өргөтгөсөн төлөвлөгөөг 10 сарын сүүлээс хийж эхэлсэн байгаа бөгөөд 12 сарын эхээр хэлэлцүүлэн батлуулах боломжтой гэж харж байгаа.</p> <p>Шилжилтийн үеийн төлөвлөгөөний хувьд бол ерөнхийдөө Камбожийн төлөвлөгөөг харах саналтай байна. Учир нь энэ дэлхийд их сайн боловсруулагдсан гэж үнэлэгдэж байна. Тэрийг яаж хийсэн гэхээр эхлээд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаан дээр үнэлгээ хийгээд ямар ажлуудыг хийх ёстой, юу хийгээгүй үлдсэн гэдэг дээр үндэслээд тогтвортой байдлын төлөвлөгөөг боловсруулсан байсан. Тэгэхээр анх бид ганц ДОХ дээр энэ төлөвлөгөөг боловсруулах гэж байсан бол одоо сүрьеэ бас ороод ирсэн байна. Тиймээс төлөвлөлт, үйл ажиллагаа, санхүүжилт, хяналт шинжилгээн дээр тус тус 1 зөвлөх нийт 4 зөвлөх авч ажиллуулан, тэдгээртэйгээ хамтран санал гаргаж гадаад зөвлөхөө авч ажиллуулж байсан дээр байх гэсэн чиглэлтэй анхны хурал өндөрлөсөн. Түүнчлэн энэхүү төлөвлөгөөг боловсруулахад бидэнд ямар нэг санхүүжилт байхгүй байна. Зөвлөхүүд авч ажиллуулах тул бид ямар нэг санхүүжилт босгон ажиллах шаардлагатай байна.</p>
МҮЭ	<p>Б.Мягмар: ҮЗЗ-ийн хувьд ЭМЯ-ыг эдгээр төлөвлөгөөний үйл явцыг түргэсгэх үүднээс ЭМС-ын дээрх 2 тушаалыг ханган идэвхитэй ажиллаасай гэж хүсэж байна. Цаашид МУ-ын хувьд олон баярууд давхцаад явах учраас 12 сардаа гол ажлуудаа нугалаасай гэж хүсэх байна.</p>
Хариулт:	
Шийдвэр:	

- Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.
- Өргөтгөсөн төлөвлөгөө болон тогвортой байдал шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд ҮЗЗ-ийн зүгээс ДЭМБ-аас санхүүжилт олгох хүсэлтийг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр гараа өргөн баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх Нууц санал хураалт
		Дэмжсэн>	14
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	

Хөтөлбөр #5 Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын талаар ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулан, санал авах.

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)> Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Оюундарь: Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын талаар ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулан /Хавсралт 6/ Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон үндэслэл нь 2018-2019 оны ҮЗЗ-ийн хэмнэгдсэн санхүүжилтыг ашиглаад дотоодын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор уул уурхайн салбарт нөлөөлөх ажил гэж анх томъёолж байсан нь явцын дунд “Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэх үндэсний зөвлөгөө” болж өөрчлөгдсөн. Өнгөрөгч гүйцэтгэх хорооны хурлаар тус зөвлөгөөнийг хамтран зохион байгуулах ажлын хэсгийг баталсан. /Ажлын хэсгийн гишүүд-Хавсралт 7/. Тус шийдвэрийн дагуу албан бичгийг дээрх байгууллагуудад хүргүүлэхэд ЗТЯ-наас л гишүүн томилон ирүүлсэн. Бусад байгууллагууд одоогоор ямар нэг хариу ирүүлэхгүй байгаатай холбоотойгоор ирэх оны ихээр зохион байгуулах болж байх шиг байна. Та бүхэнд удирдамж, хөтөлбөрийг тарааж өгсөн байгаа та бүхэн үзэж танилцаад өөрсдийн саналыг хэлнэ үү.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

Шашны байгууллага	Ж.Одгарьд: Зөв зүйтэй ажил байх гэж бодож байна. Дээр нь нэмэх санал байна, бид 2019 оноос хойш хорих ангиудаар явж байхад Сүрьеэгийн халдвар хамгааллын асуудлыг шийдвэрлэн зангидаж чадахгүй байгааг харсан. Тэгэхээр энэ удаа зам тээврийн салбар гэж байгаа бол дараагийн шатанд хорих ангиудад зориулсан нөлөөллийн ажил хийх хэрэгтэй санагдаж байна. Энэ талаар санхүүжилтын боломж байдаг боловуу.
МҮЭ	Б.Мягмар: Бусад орнуудын ҮЗЗ-ийн үйл ажиллагааг харж байхад нөлөөллийн үйл ажиллагааг чамгүй хийж байгаа харагддаг. Уул уурхай болон ЭМЯ-ны саналаар оруулсан зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх тал дээр энэ удаадаа ажиллаад дараа дараагийн өөр салбарт орж ажиллахад төсөв мөнгөний боломж гарвал ажиллах боломжтой гэж харж байна. Энэ бол төлөвлөгөөт бус хэмнэгдсэн төсвөөр хийгдэх гэж байгаа ажил бөгөөд 150 хүн оролцохоор төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд талуудтай хамтран ажиллах талаар албан бичгийг хүргүүлэхэд хариу ирээгүй байдалтай байна.

Шийдвэр:

Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын удирдамж болон хөтөлбөрийг эргэн харж харилцаа хамаарал уялдаа холбоог илүү сайжруулан ажиллах хэрэгтэй бөгөөд ажлын хэсгийн гишүүдэд яг шаардлагатай байгууллагуудыг оруулах саналтай байгааг Ажлын хэсгээ байгуулсаны дараа хамтран хэлэлцэж төлөвлөгөөндөө тусган ажиллахыг ҮЗЗ-ийн гишүүд дэмжин баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар			
Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	13
		Эсрэг>	
		Санал өгөхөөс түдгэлзэх	
Хөтөлбөр #6	Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжийг танилцуулж батлах <i>Асуулт хариулт</i>		
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.			
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>			
			Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй			
Л.Батгүвшин: Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжийг танилцуулж. /Хавсралт 8/			
БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ			
Зөвлөмж хүргүүлэх тухай			
<p>Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн Үндэсний зохицуулах зөвлөл/ҮЗЗ/ нь Үндэсний хэмжээнд хэрэгжих төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулж Глобаль Санд өргөн барих; төсөл хэрэгжүүлэх Үндсэн хүлээн авагч байгууллагыг сонгон шалгаруулах; батлагдсан төслийн хэрэгжилтэд хяналт тавих; төслийн дахин хуваарилалтыг шийдвэрлэх; Глобаль Сангийн төслийг МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөртэй уялдуулах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг салбар төлөөлөл бүрийн нийт 21 гишүүнтэй бөгөөд ҮЗЗ-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дагуу баталсан Хяналтын төлөвлөгөөний дагуу Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ/ДОХ, сүрьеэгийн төслүүдийн Хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлыг ҮЗЗ-ийн гишүүн Ж.Мөнхжаргал, Ц.Адъяахишиг, Л.Батгүвшин, Б.Сувд, зохицуулагч Б.Оюундарь, ХӨСҮТ-ийн БЗДХ-ын ТСА-ныдаргаН.Ганболд, ХӨСҮТ-ийн СТСА-ны их эмч П.Насанжаргал нар 2019 оны 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд Булган аймагт ажиллалаа. Хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлын хэсгээс дараах зөвлөмжүүдийг хүргэж байна.Үүнд:</p>			
<u>Сүрьеэгийн хөтөлбөр:</u>			
<ol style="list-style-type: none"> Шинээр баригдсан эмнэлэгт шилжин орох үед механик агааржуулалтын систем, урсгал, эмэнд мэдрэг, эмэнд тэсвэртэй, халдвартай хэлбэр, хүүхдийн өрөө, халдвартай халдваргүй бүс зэрэгт төлөвлөлт хийх; ЭМС-ын 2017 оны 8-р сарын 3-ны өдрийн А/306 дугаар тушаалын дагуу эмч мэргэжилтнүүдийг орон тоогоор нь ажиллуулах (6 орон тооны дутагдалтай: 1 эмч, 2 сувилагч, 3 үйлчлэгч); Лабораторит био-аюулгүйн шүүгээ байхгүй нь лаборантыг халдвар авах өндөр эрсдэлд оруулж байгааг анхаарч стандартын дагуу ажиллах нөхцлөөр хангах; Өвчтөнүүдийн 70 гаруй хувь нь суманд эмчилгээтэй байгаа ч хяналт хийгдээгүй тул ЭМС-ын 2017 оны 8-р сарын 3-ны өдрийн А/306 дугаар тушаалын Сүрьеэгийн хавьтлын илрүүлэлт, хяналтын зааврыг мөрдөж ажиллах; Идэвхитэй болон идэвхигүй илрүүлэлтийн урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх; Сүрьеэ хариуцсан тархвар судлагч эмчийг ХӨСҮТ-ийн СТСА-нд сүрьеэгийн хавьтлын тандалт, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр дадлагажуулах; Рентген эмчийг сургах; 			

8. ЭМГ-ын тархвар судлагч, сум, өрхийн эрүүл мэндийн төв, сүрьеэгийн диспансертай хамтран сүрьеэгийн хавьтлын тандалтыг хийж, давтан үзлэг шинжилгээний хамрагдалтыг сайжруулах.
 - а. ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр:
 1. 2017 оны 8-р сарын 3-ны өдөр баталсан ЭМС-ын А/305 дугаар тушаалын дагуу эмчилгээний стандартыг мөрдөж ажиллах;
 2. Кабинетын зохион байгуулалтыг сайжруулах;
 3. Урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулах;
 4. Анхан шатны баримт бичгийг стандартын дагуу хөтлөх, цахим болон дүн бүртгэлийн мэдээллүүд зөрүүтэй байгааг анхаарч, ажиллах;
 5. БЗДХ-ын эмч бэлтгэж дээрх тушаалын дагуу орон тоогоор нь тогтвор суурьшилтай ажиллуулах;
 6. Төслийн хүрээнд ханган нийлүүлсэн эм, тарианы хугацааг тогтмол шалгаж, хугацаа дуусахаас өмнө бусад аймаг, дүүрэгтэй солилцох зэрэг менежментийг хийж занших
 7. Төслийн шугамаар ханган нийлүүлсэн эм, тариаг устгалд оруулахгүй, үргүй зардал гаргахаас зайлсхийх. Хугацаа дуусах дөхсөн эм, тариаг өөр аймагтай солилцох;
 8. Үйлчлүүлэгчийн нууц задрахаас сэргийлж хувь хүний нууцыг хадгалахад анхаарлаа хандуулах.
 - б. Дээрх зөвлөмжүүдийн дагуу авсан арга хэмжээний тайланг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ үү.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Сүрьеэгийн хөтөлбөр:

1. Сүрьеэ хариуцсан тархвар судлагчийг ЭМС-ын 2017 оны 08 дугаар сарын 03-ны А/306 тушаалд заасны дагуу хавьтлын хяналт, тандалт судалгаа, голомтын арга хэмжээ авч ажиллуулах;
 2. Хүний нөөцийн дутагдал, үйл ажиллагааны алдаа дутагдлыг яаралтай арилгах (Сүрьеэгийн тасагт ганцхан үйлчлэгч ажиллаж байгаа нь халдвар хамгааллын хувьд ноцтой зөрчил юм, эмийн сувилагч);
 3. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ явуулах нөхцөл бүрдээгүй, хэвтэн эмчлүүлэгчдийн нөхцөл туйлын тааруу байгаад анхаарч шинэ байранд орох үед дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарах;
 4. Шинээр баригдаж байгаа эмнэлгийн зохион байгуулалт, механик агааржуулалтын систем, урсгал, халдвартай халдваргүй бүсээр зааглах, өрөө тасалгааны хүртээмж зэрэгт санаачлага гарган ажиллах
- Тухайлбал:

1-р давхарт

- Эрүүлзүйн үзлэгийн өрөө
- Сорил тавих өрөө
- Лаборатори
- Мэдрэг сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэг
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өдрийн эмчилгээний цэг
- Эмч, ажилчдын амралтын өрөө

2-р давхарт

- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний палат дор хаяж 2
 - Эмэнд мэдрэг сүрьеэгийн хувьд нян судлалаар эерэг, сөрөг, эмэгтэй, хүүхэд гэх мэтээр халдвартай халдваргүй бүс үүсгэн хаалт хамгаалалт хийх
 - Эмч ажилчдын өрөөг халдваргүй бүсэд байршуулах
5. Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хавьтлын үзлэг шинжилгээнд хамрагдалтыг 95%-д хүргэх, хавьтлын давтан үзлэг, хяналтыг чанаржуулах;
 6. Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх нөхцлийг бүрдүүлэх, халдвар хамгааллын шаардлага хангасан өрөө, өдрийн эмчилгээний цэг нээх;
 7. Цэрний сорьц авах кабиныг угсарч ашиглах;
 8. Сүрьеэгийн лабораторит Жене эксперт аппаратад зайлшгүй шаардлагатай дагалдах хэрэгслийг хангах (принтер, холигч /vortex)

ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр:

1. Оношийн олон улсын кодлол дутагдалтай, нэг системд оруулах. Оношийн ангилал, анхан шатны бичиг

- баримтыг цэгцлэх;
2. Үзлэгийн өрөөний зохион байгуулалтыг сайжруулах;
 3. Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалахад анхаарлаа хандуулж ажиллах;
 4. 2017 оны 8-р сарын 3-ны өдрийн А/305 дугаар тушаалд заасны дагуу хүний нөөцтэй ажиллах;
 5. Мэдээллийн ил тод байдлын журмын /ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоол/ хэрэгжилтэнд анхаарч, үйл ажиллагааны тайланг тайлангийн хугацаанд болон тухайн үеийн байдлаар гаргаж, цахим бүртгэлжүүлж, нийтэд ил тод болгох
- Зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ үү.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	<p>Ц.Адъяахишиг: Миний бие Хөвсгөл, Булган аймагт ажилласан тайлан болон тухайн аймгуудад явуулах зөвлөмжийн төсөлтэй танилцаад тухайн үед буюу 10 дугаар сарын эхээр өөрийн саналаа мэйлаар явуулсан гэж бодоод байдаг. Гэтэл илгээсэн захидлын хайрцагтаа бас хайгаад олдоггүй ээ. Тэгэхээр миний хариуцлагагүй байдлаас болж саналаа илгээгүй байна. Тухайн үед бичиж байсан саналаа дахин илгээсэн.</p> <p>Ер нь аливаа зөвлөмж тодорхой ойлгомжтой, хэрэгжихүйц байх ёстой. Тиймээс зөвлөмжийг бэлтгэн хүргүүлэхдээ ЭМС-ын тушаалыг эдгээр үндэслэлээр хангахгүй байгаа учраас нийцүүлж, зохион байгуулалтыг өөрчлөх гэх мэтээр илүү дэлгэрэнгүй тодорхой байдлаар өгвөл зүгээр санагдаж байна. БЗДХ-ын кабинет ямар байх ёстой гэдэг шаардлагыг тусган явуулах хэрэгтэй санагдсан. Түүнчлэн зөвлөмжийн үг үсэг, найруулгыг сайжруулан ойлгомжтой байдлаар хүргэх хэрэгтэй гэж санагдаж байна. Тиймээс эдгээр зөвлөмжүүд дээр хамтран ажиллаж илүү сайжруулах хэрэгтэй гэсэн саналтай байна.</p> <p>Зөвлөмжийг хүргүүлээд эргээд хэн эдгээр үйл ажиллагаа хэрэгжиж байгаад хяналт тавих ёстой вэ?</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: ҮЗЗ-ийн үүрэг нь төсөл хөтөлбөрт хяналт шалгалт хийх бус ерөнхий хяналтыг хийхэд оршдог. Энэ ч утгаараа хөдөө орон нутаг, байгууллагуудад танилцах айлчлал хийгээд зөвлөмжийг ҮХА буюу ЭМЯ-д өгдөг. Улмаар ҮХА нь тухайн байгууллагуудад шаардлагатай арга хэмжээг авч, засаж сайжруулах үүрэгтэй. Тэгэхээр илүү харьцаж шалгах үүрэггүй.</p>
ТБ	<p>Ж.Мөнхжаргал: ҮЗЗ-ийн дүрмийн 12.12-т зааснаар тус сангаас санхүүжилт авч төсөл хэрэгжүүлж байгаа үндсэн болон салбар хүлээн авагчийн төслийн үйл ажиллагаатай танилцах, шаардлагатай гэж үзвэл 10-аас дээшгүй гишүүдийн бүрэлдэхүүнтэй хянан шалгах үйл ажиллагааг хийх гэсэн заалт байгаа учраас бид хяналт шалгалт хийх эрхтэй чухам хэрхэн, яаж хийх вэ гэдгийг цаашид ярилцаж болно.</p>

Шийдвэр:

Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжид гишүүдийн гаргасан саналыг тусган хэрэгжихүйц байдлаар Эрүүл Мэндийн Сайд болон тухайн орон нутгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүлэх хэрэгтэй. Үг, өгүүлбэрийн хувьд ХӨСҮТ-ийн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө, тусламжийг авч мэргэжлийн үг хэллэг хэрэглэх хэрэгтэй байгаан дээр зөвлөмжийн удиртгал хэсэгт байгаа оролцсон гишүүдийн нэрсийг албан тушаалын хамт оруулах хэрэгтэй. Мөн хугацааны хувьд гишүүдтэйгээ ярилцан цаашид яаж хэрэгжих боломжтой талаар төлөвлөгөөтэй хүргүүлэх хэрэгтэй гэсэн саналыг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт	Гар өргөх	
		(Тохирох нүдийг бөглөнө үү)	Нууц санал хураалт	
		Дэмжсэн>	11	
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		

Хөтөлбөр #7 **Зохион байгуулалтын асуудал:**

- ҮЗЗ-ийн даргын хугацааг хэлэлцэх
- Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

Б.Оюундарь, ҮЗЗ-ийн ажлын албаны зохицуулагч: ҮЗЗ-ийн 81 дэх удаагийн хурлаар энэ асуудлыг хэлэлцээд шийдвэрлээгүй орхисон учраас өнөөдрийн хурлаар дахин оруулж ирж байна. ҮЗЗ-ийн даргын тухай асуудал дүрмийн 4 дэх хэсэгт байгааг та бүхэн тараан өгсөн дүрмээс харна уу. Одоогийн нөхцөл байдлыг харахад дараагийн 3 жилийн төслийг өргөн барих чухал цаг үе ирсэн учраас тогтвортой байдлыг хангах үүднээс ҮЗЗ-ийн зарим нэг гишүүдээс Даргыг үргэлжлүүлэн ажиллуулах санал ирсэн. Тиймээс мэргэжлийн хуульчаас зөвлөгөө тусламж аван ҮЗЗ-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахаар дараах саналын хувилбаруудыг боловсрууллаа.

ҮЗЗ-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал /Хавсралт 9/

Хувилбар 1

7.31 ҮЗЗ-ийн дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацааг дахин нэг удаа улируулан сунгах саналыг ҮЗЗ-ийн гишүүн гаргасан бол энэ дүрмийн 7.3.1, 7.3.8 дахь заалт тус тус хамаарахгүй.

Хувилбар 2

4.5 ҮЗЗ-ийн дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацааг дахин нэг удаа улируулан сунгаж болох ба саналыг ҮЗЗ-ийн 50%-аас дээш гишүүн гаргасан бол улируулан сунгаж болно.

7.3.9 Дүрмийн 4.5-д заасны дагуу ҮЗЗ-ийн дарга, дэд даргыг дахин нэг удаа улируулан сонгохоор шийдвэрлэсэн бол 7.3.1, 7.3.8 дахь заалтууд тус тус хамаарахгүй.

Та бүхэн дээрх саналтай танилцан аль тохиромжтой санагдсан дээр саналаа ирүүлнэ үү.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ТБ	<p>Ж Мөнхжаргал: Миний хувьд энэ асуудлыг өмнөх ҮЗЗ-ийн хурлаар санал оруулан хэлэлцүүлж байсан. Тэгээд би ҮЗЗ-ийн даргатайгаа хамтран ажиллах дуртай байгаа бөгөөд үйл ажиллагаагаа ханган ажиллахад манлайлалтай оролцдог гэж үздэг. Гэхдээ зарчмын хувьд дарга хэн ч байсан боловсруулсан дүрмийн дагуу 2 жил байх дүрмээ баримтлах хэрэгтэй гэсэн саналаар оруулж ирсэн. Одоо энэ асуудлыг дахин ярилцаж байна. Гэвч бид ганц хүнийг даргаар авч үлдэхийн тулд дүрмээ өөрчилж болохгүй байгаа. Ингэснээр маш олон зарчмын зөрүүтэй асуудал орж ирнэ. Тэгэхээр бидэнд нэг гарц байгаа бөгөөд</p> <p>7.3.3 ҮЗЗ-ийн нийт гишүүдийн 51 хувь буюу түүнээс дээш гишүүн бүрэн эрхийг дуусгавар болгох тухай үндэслэл бүхий санал бичгээр гаргасан;</p> <p>7.3.7 Дарга, дэд даргын бүрэн эрхийг дуусгавар болгох тухай асуудлыг нийт гишүүдийн гуравны хоёр хувийн буюу 70 хувийн саналаар шийдвэрлэнэ. Гэсэн байгаа тул одоогоор эдгээр асуудлаар санал гаргасан гишүүн байхгүй тул хойшлуулах боломжтой харагдаж байна.</p>
ЭМЯ-ҮХА	<p>Б.Цогтбаатар: Ажлын албаны зохицуулагч Б.Оюундариас асуулт асуух байна. Түрүүн тогтвортой байдлыг хангах үүднээс ҮЗЗ-ийн зарим нэг гишүүдээс Даргыг үргэлжлүүлэн ажиллуулах санал ирсэн. Тиймээс мэргэжлийн хуульчаас зөвлөгөө тусламж аван ҮЗЗ-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахаар дараах саналын хувилбаруудыг боловсрууллаа гэж хэлсэн. Тэгвэл энэ тал дээр яг ямар гишүүн, хэзээ ямар санал гаргасныг тодруулж өгөөч.</p>
ҮЗЗ-АА	<p>Б.Оюундарь: ҮЗЗ-ийн өмнөх хурал дээр Ж.Мөнхжаргал гишүүн тус саналыг оруулан хэлэлцүүлж байсан. Мөн энэ хурал дээр саналаа өгсөн бөгөөд бусад гишүүд албан бусаар саналаа өгсөн яг хэн хэлсэнг тодорхой санахгүй байна. Түүн дээр үндэслэн мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авч эдгээр саналуудыг оруулж ирж байна.</p>
Хувийн хэвшил	<p>Б.Мягмар: Миний хувьд ҮЗЗ-ийн даргаар байх сонирхол үнэхээр байхгүй байгаа бөгөөд өөрийн үндсэн ажлын ачаалал маш өндөр байдаг. Хэрэв ҮЗЗ-ийн даргаар ажиллах боломжтой хүн байвал би дуртайяа ажлаа хүлээлгэн өгмөөр байна гэдгийг би өмнөх хурлын үеэр ч хэлж байсан. Түүнээс бус энэхүү орж ирж байгаа санал болох хүнд тааруулж дүрэм хийнэ гэдэг бол утгагүй асуудал юм. Б.Оюундарь үүн дээр саналаа боловсруулаад гишүүд санал хэлсэн байх, түүнээс миний хувьд энэ дүрмийн томъёоллыг огт үзээгүй. Тиймээс дүрмээ өөрчлөх гэдэг саналтай би санал нийлэхгүй байна.</p>
ЭМЯ-ҮХА	<p>Б.Цогтбаатар: Өнөөдөр ҮЗЗ-ийн дарга, дэд даргын асуудлаар гишүүдийн байр суурийг сонсох саналтай байна.</p>
ТХА	<p>Г.Нямпүрэв: Миний хувьд дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж бодож байна. 2 жил гэдэг бол хангалттай хугацаа биш. Тогтвортой байдлын тухайд хэлэхэд, Жишээ нь бүсийн 8 орны төсөл дээр манай 1 гишүүн явсан боловч буцаж ирээд мэдээлэл өгөөгүй. Дээрээс нь дахиад</p>

	12 сард өөр хүн явах гэж байгаа гэх мэт Монгол улсын ҮЗЗ-ээс тохиромжгүй байдал харагдаж байна. Түүнчлэн 2021-2023 оны төслийг хэлэлцэн батлахад бидэнд их ажил төлөвлөгдөж байгаа бөгөөд түүнээс өмнө ҮЗЗ-ийн даргыг солихгүй байвал зүгээр байх гэсэн саналтай байна. Харин цаашид бол ҮЗЗ-ийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Өнгөрсөн жил энэ дүрмийг батлахад олон зүйл дээр санал нийлэхгүй байсан ч сүүлдээ баталсан.
ТБ	Ц.Адъяахишиг: ҮЗЗ-ийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг гүйцэтгэх хороогоор хэлэлцсэн үү? 15.2 Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ҮЗЗ-ийн хурлаар шийдвэрлэх бөгөөд ҮЗЗ-ийн нийт гишүүдийн 51 хувиас дээш саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно гэсэн байна. Тэгвэл дүрэмд өөрчлөлт оруулах өөр ямар хэрэгцээ, шаардлага байгаа вэ? Тэдгээр асуудлуудаа нэгтгээд түүний дараа энэ дүрэмд өөрчлөлт оруулах асуудлаа ярьж гэсэн саналтай байна.
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: ҮЗЗ-ийн гүйцэтгэх хороогоор өнөөдрийн энэ хурлын товыг хэлэлцэн баталсан. Даргын асуудлыг оруулах саналыг баталсан боловч яг ямар байдлаар оруулахыг олон талаас нь судлаад хамгийн боломжит хувилбарыг оруулахаар тохирсон.
Шашны байгууллага	Ж.Одгарьд: 15.2-ыг үндэслэн дүрэмд өөрчлөлт оруулах саналтай байна. Ер нь тогтвортой байдал чухал гэж байна. Бид багагүй хугацааг хамт явж өнгөрөөлөө. Харьцуулахад одоогийн ажиллаж буй дарга, дэд дарга болон ажлын албаны ажилчдын хүчин чармайлт нөлөөлж байгаа гэж бодож байна. Тиймээс энэ байдлыг дараагийн төсөл өргөн барих хүртэл яаж хадгалах вэ гэдгийг давхар бодоод дүрэмдээ өөрчлөлт оруулах хэрэгтэй санагдаж байна. Улмаар одоогийн нөхцөл байдалд давуу байдал үүсэх байх гэж харж байна. Хэрэв дүрэмд өөрчлөлт оруулахгүй бол даргын сонгууль явуулах болж байна.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: За, гишүүдийн саналыг үндэслэн санал хураахад ҮЗЗ-ийн гишүүдийн 51%-д хүрч байна уу?
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: Өнөөдрийн ҮЗЗ-ийн хурлаар бид 52%-ийн ирцтэй байсан боловч яг одоогоор 10 гишүүн үлдсэн байна.
ТБ	Ц.Адъяахишиг: Миний бодлоор дүрэмд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагаа тодорхойлоод, яг энэ хэсэгт учир дутагдалтай байгаа тул саналаа ирүүлнэ үү гээд и-мэйлээр саналыг нь авч, улмаар өөрчлөлтийг хийх саналтай байна.
ҮЗЗ-АА	Б.Оюундарь: 5.3.2 гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ҮЗЗ-ийн хуралд 2 удаа ирээгүй бол ҮЗЗ-ийн гишүүнээс хасагдана гэж тодорхой заасан байна. Тиймээс дараагийн хурлаас энэ асуудлыг шийдвэрлэн ажиллах болно.
ЭМЯ-УХА	Б.Цогтбаатар: Анх яригдсан асуудалд шийдэл олох үүднээс 2021-2023 оны төслийг боловсруулан өргөн барьталаа одоогийн ҮЗЗ-ийн даргаа ажиллаж өгнө үү гэсэн хүсэлтийг албан ёсоор тавих болоод байна.
МҮЭ	Б.Мягмар: Тогтвортой байдлыг хангах үүднээс энэхүү саналыг хүргэж байгаа бол 2020 оны 03 сарын 23-ны өдөр буюу дараагийн төслийг өргөн барих хүртэл энэ үүргээ гүйцэтгээд, тэр хүртэлх хугацаанд дараагийн ҮЗЗ-ийн даргын нэрийг дэвшүүлэн, одоогоос бэлтгэх хэрэгтэй.

Хариулт

Шийдвэр:

2021-2023 оны төслийг боловсруулан өргөн барьталаа ажиллах үүргийг одоогийн ҮЗЗ-ийн дарга Б.Мягмарт албан ёсоор тавихыг хуралд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.

Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох асуудлыг ирц хангалтгүй байгаа тул дараагийн хурлаар хэлэлцэхээр гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.

ҮЗЗ-ийн хуралд ирж оролцдоггүй гишүүдэд орны гишүүн томилуулах болон олон тасалсан гишүүдийн холбогдох байгууллагуудад зохих дүрмийн заалтыг оруулсан албан бичгийг хүргүүлэн гишүүн шинээр томилуулах хүсэлт хүргүүлэх ажлыг ҮЗЗ-ийн Ажлын Албаны зохицуулагч Б.Оюундарьт даалгалаа.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х		
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх
			Нууц санал хураалт
		Дэмжсэн>	10
		Эсрэг>	

Санал өгөхөөс түдгэлзэх

ШИЙДВЭР, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр		ХАРИУЦАЖ БУЙ ХҮН	ХУГАЦАА
хөтөлбөр#4	<ul style="list-style-type: none"> Глобаль сангийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа. Өрөтгөсөн төлөвлөгөө болон тогвортой байдал шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд ҮЗЗ-ийн зүгээс ДЭМБ-аас санхүүжилт олгох хүсэлтийг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр гараа өргөн баталлаа. 	Ажлын хэсэг, ДЭМБ	
хөтөлбөр#5	Уул уурхай, зам тээврийн салбар дахь ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын удирдамж болон хөтөлбөрийг эргэн харж харилцаа хамаарал уялдаа холбоог илүү сайжруулан ажиллах хэрэгтэй бөгөөд ажлын хэсгийн гишүүдэд яг шаардлагатай байгууллагуудыг оруулах саналтай байгааг Ажлын хэсгээ байгуулсаны дараа хамтран хэлэлцэж төлөвлөгөөндөө тусган ажиллахыг ҮЗЗ-ийн гишүүд дэмжин баталлаа.	Ажлын хэсэг	2020 оны 1 сар
хөтөлбөр#6	Булган, Хөвсгөл аймгуудад хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах ажлаас гарсан зөвлөмжид гишүүдийн гаргасан саналыг тусган хэрэгжихүйц байдлаар Эрүүл Мэндийн Сайд болон тухайн орон нутгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүлэх хэрэгтэй. Тэгэхийн тулд үг, өгүүлбэрийн хувьд ХӨСҮТ-ийн мэргэжлийн эмч нараас зөвлөгөө, тусламжийг авч мэргэжлийн үг хэллэг хэрэглэх хэрэгтэй байгаан дээр зөвлөмжийн удиртгал хэсэгт байгаа оролцсон гишүүдийн нэрсийг албан тушаалын хамт оруулах хэрэгтэй. Мөн хугацааны хувьд гишүүдтэйгээ ярилцан цаашид яаж хэрэгжих боломжтой талаар төлөвлөгөөтэй хүргүүлэх хэрэгтэй гэсэн саналыг ҮЗЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа.	ҮЗЗ-ийн гишүүд	
хөтөлбөр#7	<ul style="list-style-type: none"> 2021-2023 оны төслийг боловсруулан өргөн барьталаа ажиллах үүргийг одоогийн ҮЗЗ-ийн дарга Б.Мягмарт албан ёсоор тавихыг хуралд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа. Хяналтын хорооны зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгох асуудлыг ирц хангалтгүй байгаа тул дараагийн хурлаар хэлэлцэхээр гишүүд санал нэгтгэйгээр дэмжин баталлаа. <p>ҮЗЗ-ийн хуралд ирж оролцдоггүй гишүүдэд орны гишүүн томилуулах болон олон тасалсан гишүүдийн холбогдох байгууллагуудад зохих дүрмийн заалтыг оруулсан албан бичгийг хүргүүлэн гишүүн шинээр томилуулах хүсэлт хүргүүлэх ажлыг ҮЗЗ-ийн Ажлын Албаны зохицуулагч Б.Оюундарьт даалгалаа.</p>	ҮЗЗ-ийн гишүүд	ҮЗЗ-ийн дараагийн 83 дахь хурал

ДАРААГИЙН ХУРАЛ(огноо, хөтөлбөр)

Огноо	2020 оны 1 дүгээр улирал	
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр	

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү			
	Тийм	Үгүй	
Хурлын тов, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		14 болон 7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон орлож ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЗГ	Засгийн Газар
СЯ	Сангийн Яам
ТБ	Төрийн Байгууллага
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТНБД	Төрийн Нарийн Бичгийн Дарга
ХЗН	Хөтөлбөр Зохицуулах Нэгж
ЭМ	Эрүүл Мэнд
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ҮХА	Үндсэн Хүлээн Авагч
СХА	Салбар Хүлээн Авагч

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2019 оны 12 сарын 09

Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	
ХЯНАСАН:			
Нэр>	Б.Оюундарь	Огноо>	2019 оны 12 сарын 09
Албан тушаал>	ҮЗЗ-ийн зохицуулагч	Гарын үсэг>	

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2019 оны 12 сарын 09
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	